

1 АУДИТЫН ТАЙЛАН

1.1 ОРШИЛ

Чингис Хаан Олон Улсын Нисэх Буудал ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Чингис Хаан олон улсын нисэх буудлын захирал Д.Мөнхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах талаар зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2017 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Чингис Хаан олон улсын нисэх буудлын удирдлага санхүүгийн тайлангаа санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлангийн программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 15-наас 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, хүргүүлэхээр төлөвлөн, “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-ийн ажлын аудитор С.Бямбаа, аудитор Ж.Отгонцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Тус байгууллага нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгыг 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдөр №0716/336 тоот албан бичгийн хамт “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

1.3 Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Чингис Хаан олон улсын нисэх буудал нь Улсын нисэхийн тухай, Иргэний нисэхийн тухай, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Зөрчлийн тухай, Авилгын эсрэг зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

1.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус байгууллага нь зорилгоо “Нисэх буудлын үйл ажиллагааг аюулгүй, шуурхай, соёлтой, үр ашигтай зохион байгуулж үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээг бүрдүүлсэн үндэсний шилдэг байгууллага болох” гэж тодорхойлсон байна.

Тус байгууллага нь Иргэний Нисэхийн Дүрэм-139, 140-ийн дагуу аэродром, аюулгүй байдлын үйлчилгээ явуулахаар гэрчилгээ авсан бөгөөд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- Нисэхийн аюулгүй байдал, харуул хамгаалалтын үйлчилгээ
- Аэродром ашиглалт
- Зорчигч үйлчилгээ
- Агаарын шуудангийн үйлчилгээ
- Авран туслах, гал унтраах ажиллагаа
- Инженер техникийн үйлчилгээ

Чингис Хаан олон улсын нисэх буудлын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан. /ТАБ-СТА-А-1/

1.5 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН


Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 8 горим, сорил 23-ыг гүйцэтгэв.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 1.10 дахь заалтад хураангуйлан тэмдэглэв.

Чингис Хаан олон улсын нисэх буудал санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн



технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Тус байгууллага санхүүгийн тайлангаа Интерактив ХХК-н “Veritech ERP” програм хангамжаар бэлтгэсэн байна.

1.6 Дотоод хяналт

Чингис Хаан олон улсын нисэх буудлын дотоод хяналт санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Чингис Хаан олон улсын нисэх буудлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Тайлант онд Зам, тээврийн хөгжлийн яамны хяналт шалгалтаар нийт 700.9 сая төгрөгийн орлогын анхан шатны баримтын бүрдэлийн талаар зөрчил илэрч зөрчлийг бүрэн арилгаж, бүртгэлд тусгасан.

1.7 Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга

Чингис Хаан олон улсын нисэх буудал нь 2017 онд нийт 26,895.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 21,960.5 сая төгрөгийн зардалтай ажилласан байна.

Тус байгууллагын 2017 оны урсгал зардалд 23,131.0 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 21,960.5 сая төгрөгийг зарцуулж 1,170.5 сая төгрөгөөр төсөв хэмнэсэн байна.

1.8 Шилэн дансны мэдээлэл

Чингис Хаан олон улсын нисэх буудал нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна.


Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад: Шилэн дансны нэгдсэн цахим мэдээллийн санд “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг”-ийг мэдээлэхээр заасны дагуу 807.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 54 гэрээний санхүүжилт 789.0 сая төгрөг, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-г мэдээлэхээр заасны дагуу 37,829.5 сая төгрөгийн 774 орлогын гүйлгээ, 26,902.1 сая төгрөгийн 230 зарлагын гүйлгээг тус бүр тайлант онд байршуулсан байна.

1.9 Олж тогтоосон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 23 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.



Санхүүгийн тайланд тооцоо нийлж баталгаажуулаагүй 58.1 сая төгрөгийн авлага, ажлаас халагдсан ажилтан 6.7 сая төгрөгийн зөөврийн компьютер, i pad-г хүлээлгэн өгөөгүй, анхан шатны баримтгүй 3.1 сая төгрөгийн бэлэн мөнгө зарцуулсан нь оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдэд нийцэхгүй байна.

1.10 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

1.10.1 Мөнгөн хөрөнгийн талаар

Тус газрын Тэргүүн дэд захирал болон Аэродромын албаны ерөнхий инженер нь анхан шатны баримтгүй, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр 3.1 сая төгрөгийг касснаас бэлнээр авч хувийн хэрэгцээнд зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр тогтов.

1.10.2 Үндсэн хөрөнгийн талаар

Ажлаас халагдсан ажилтан 6.7 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер, i pad-ыг хүлээлгэн өгөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр тогтов.

1.10.3 Авлагын талаар


Тайлант онд 58.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 58.1 сая төгрөгийн авлагыг холбогдох байгууллагад хандаж барагдуулах талаар зөвлөмж өгөх

1.11 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд навигацийн орлогоос 2,000.0 сая төгрөгийг 2017 оны 10 сарын 30-ны өдөр шилжүүлсэн бөгөөд уг мөнгө төрийн сангийн дансанд төвлөрүүлэх ёстой гэтэл дээрх гүйлгээг Капитал банк нь шилжүүлэлгүй 2 сар өөрийн дансанд байршуулсан байна. ЧХОУНБ -ын 2017 оны 12-р сарын 26-ны өдрийн Б/2007 тоот албан бичгийн дагуу харилцагчийн хүсэлтээр 12 сарын 28-ны өдөр Капитал банк нь ЧХОУНБ-ын дээрх дансанд буцаан шилжүүлсэн байна. Энэ нь улсын төсвийн бүрдүүлэлтийг 2 сараар саатуулсан, төрийн өмчит үйлдвэрийн газрын мөнгөн хөрөнгийг хувийн арилжааны банканд байршуулсан.

Тус газарт 2017 онд Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Үндэсний аудитын газар, Иргэний нисэхийн ерөнхий газраас аудитын шалгалт орж, дээрх асуудлын талаар арилжааны банканд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангасан, төлбөр гүйцэтгэх чадвартай арилжааны банканд улсын мөнгөн хөрөнгийг байршуулж төлбөр тооцоо хийх, бүтээлэг санхүүгийн аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон байна.



1.12 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Тус байгууллагын орлогын Капитал банк дахь 2061002679 тоот харилцах дансыг 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй тул дараагын аудитаар үргэлжлүүлэн мөшгөн шалгах шаардлагатай гэж үзлээ.

1.13 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 67.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 58.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 9.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

1.14 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага дансны өсөлт, мастикийн үлдэгдэл өндөр байгаа талаар 294.1 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.

1.15 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоор сонгов.

Тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 28,403,453.5 сая төгрөгийн 1 хувиар буюу 284.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо. Шинж чанар орчин нөхцөлөөр тооцоход материаллаг шинжтэй зүйлс илрээгүй болно.

1.16 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Зөрчилгүй санал дүгнэлт

Чингис Хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.



2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Чингис Хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



2.1 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Аудиторын ажиглалт

Тайлант онд 58.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, найдваргүй авлага үүсэх.

Аудиторын зөвлөмж

58.1 сая төгрөгийн авлагыг холбогдох байгууллагад хандаж барагдуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 сарын 1-нд үндэсний аудитын газарт хүргүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**


3 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлынтайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,478,207,330.67	5,975,888,182.38
Дансны авлага	13,797,789,915.40	12,808,069,224.88
Татвар, НДШ – ийн авлага	20,394,621.84	47,635,247.50
Бусад авлага	138,170,642.84	161,754,137.51
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	782,518,717.32	782,749,851.90
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	136,779,316.00	146,330,000.00
Бусад эргэлтийн хөрөнгө	5,547,500.00	5,547,500.00
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
Системийн авлага		
Эргэлтийн хөрөнгийн дүн	17,359,408,044.07	19,927,974,144.17
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	48,522,084,291.68	46,213,949,046.79
Биет бус хөрөнгө	131,774,436.66	97,618,798.30
Дуусаагүй барилга		
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		187,996,756.06
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
Хуримтлагдсан элэгдэл		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	48,653,858,728.34	46,499,564,601.15
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	66,013,266,772.41	66,427,538,745.32
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	3,190.00	46,350,853.07
Цалингийн өглөг	2,012,945.35	
Татварын өр	77,556,606.83	28,232,530.90
НДШ - ийн өглөг		866,224.30
Богино хугацаат зээл		
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого	151,600,496.37	50,557,447.88
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр	416,062,367.17	136,639,416.35
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
Системийн өглөг	11,233,075,857.18	7,979,657,357.39
Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,930,311,462.90	8,233,293,829.89
Урт хугацаат өр төлбөр		



Урт хугацаат зээл		
Нөөц /өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр		
Урт хугацаат бондын өглөг		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Өр төлбөрийн нийт дүн	11,930,311,462.90	8,233,203,829.89
Эздийн өмч		
Өмч: - төрийн		
- хувийн		
- хувьцаат		
Нэмж төлөгдсөн капитал		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хойшлогдсон орлого		
Хуримтлагдсан ашиг	54,082,955,309.51	58,194,334,915.43
Эздийн өмчийн дүн	54,082,955,309.51	58,194,334,915.43
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	66,013,266,772.41	66,427,538,745.32



3.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Борлуулалтын орлого (Цэвэр)	23,103,761,246.36	26,895,302,083.00
Борлуулалтын өртөг	16,786,303,515.65	22,818,421,610.14
Нийт ашиг (алдагдал)	6,317,457,730.71	4,076,880,472.87
Түрээсийн орлого	1,192,771,203.38	1,943,633,738.68
Хүүний орлого	59,243,718.92	273,874,808.21
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	998,332,239.70	1,849,717,206.26
Борлуулалт маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	1,721,931,056.24	1,443,111,902.10
Санхүүгийн зардал		
Бусад зардал	1,807,446,297.74	1,863,985,301.51
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	471,027,103.85	-34,856,874.11
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,509,454,642.58	4,802,152,148.30
Орлогын татварын зардал		690,772,542.38
Татварын дараах ашиг (алдагдал)	5,509,454,642.58	4,111,379,605.92
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5,509,454,642.58	4,111,379,605.92
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Бусад олз гарз		
Орлогын нийт дүн		
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



3.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		5,812,426,359.67	5,812,426,359.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-5,812,426,359.67	-5,812,426,359.67
Залруулсан үлдэгдэл			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		5,509,454,642.59	5,509,454,642.59
Бусад дэлгэрэнгүй орлого			
Өмчид гаргасан өөрчлөлт		48,573,500,666.92	48,573,500,666.92
Зарласан ногдол ашиг			
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
2016 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл		54,082,955,309.51	54,082,955,309.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
Залруулсан үлдэгдэл		54,082,955,309.51	54,082,955,309.51
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		4,111,379,605.92	4,111,379,605.92
Бусад дэлгэрэнгүй орлого			
Өмчид гаргасан өөрчлөлт			
Зарласан ногдол ашиг			
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
2017 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл		58,194,334,915.43	58,194,334,915.43

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	24,938,662,303.82	33,326,279,956.54
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	21,890,715,700.48	29,448,076,467.81
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
ҮҮА-ны бусад мөнгөн орлого	3,047,946,603.34	3,878,203,488.73
Мөнгөн зарлагын дүн (-)	24,213,079,585.32	29,887,044,003.80
Ажиллагчдад төлсөн	11,978,747,241.02	14,105,111,986.03
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,969,403,445.00	3,102,530,520.00
Бараа материал худалдан авахад төлсөн	1,081,226,044.71	1,341,290,877.95
Ашиглалтын зардалд төлсөн	315,970,945.38	496,859,152.82
Хүүний төлбөрт төлсөн		
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	242,979,570.90	17,656,000.00
Татварын байгууллагад төлсөн	1,775,279,761.97	2,514,907,133.94
Даатгалын төлбөрт төлсөн	-	0
ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	5,849,472,576.34	8,308,688,333.06
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	725,582,718.50	3,439,235,952.74
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	59,243,718.92	256,417,273.97
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	59,243,718.92	256,417,273.97
Хүлээн авсан ногдол ашиг		
ХО бусад мөнгөн орлого		
Мөнгөн зарлагын дүн (-)	166,212,987.92	197,972,375.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	166,212,987.92	189,413,375.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		8,559,000.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
ХО бусад мөнгөн зарлага		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(106,969,269.00)	58,444,898.97
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
СҮА-ны бусад мөнгөн орлого		
Мөнгөн зарлагын дүн (-)		
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
СҮА-ны бусад мөнгөн зарлага		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	618,613,449.50	3,497,680,851.71
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	618,613,449.50	3,497,680,851.71
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,859,593,881.17	2,478,207,330.67
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,478,207,330.67	5,975,888,182.38




3.5 Зардлын төлөвлөгөө гүйцэтгэл

Зардлын нэр	Төлөвлөгө	Тодотгол	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Хэтрэлт хэмнэлт тоогоор	%
НИЙТ ЗАРЛАГА	21,953,954,400.0	23,131,093,900.0	21,960,449,375.9	1,170,644,524.1	5
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,328,064,800.0	21,409,340,400.0	19,952,056,816.3	1,457,283,583.7	7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	14,317,836,700.0	15,066,622,600.0	14,094,984,385.4	971,638,214.6	7
Үндсэн цалин	12,612,363,700.0	13,361,149,600.0	12,414,959,985.5	946,189,614.5	8
Унаа хоолны хөнгөлөлт	1,705,473,000.0	1,705,473,000.0	1,680,024,400.0	25,448,600.1	1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,701,085,700.0	1,807,994,700.0	1,717,730,615.6	90,264,084.4	5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	825,000,000.0	936,000,000.0	905,849,472.3	30,150,527.7	4
Гэрэл, цахилгаан	540,000,000.0	625,000,000.0	632,059,665.4	-7,059,665.3	-1
Түлш, халаалт	200,000,000.0	200,000,000.0	162,791,252.1	37,208,747.9	19
Цэвэр, бохир ус	85,000,000.0	111,000,000.0	110,998,554.8	1,445.2	0
Хангамж, бараа материалын зардал	1,323,181,100.0	1,344,083,900.0	1,264,428,563.9	79,655,336.1	6
Бичиг хэрэг	65,000,000.0	70,000,000.0	64,951,667.9	5,048,332.2	8
Тээвэр, шатахуун	468,836,000.0	468,836,000.0	461,388,587.4	7,447,412.6	2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	80,000,000.0	80,000,000.0	81,342,979.1	-1,342,979.1	-2
Хог хаягдал зайлуулах, цэвэрлэгээний зардал	685,247,900.0	685,247,900.0	617,175,937.3	68,071,962.7	10
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,097,200.0	40,000,000.0	39,569,392.2	430,607.8	2
Нормативт зардал	828,478,200.0	778,478,200.0	519,626,428.0	258,851,772.0	31
Хоол, хүнс /түүхий эд материал	678,478,200.0	628,478,200.0	449,227,288.4	179,250,911.6	26



Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000,000.0	150,000,000.0	70,399,139.6	79,600,860.4	53
Эд, хогшил, урсгал засварын зардал	759,613,000.0	804,000,000.0	803,536,442.8	463,557.2	0
Барилга	205,600,000.0	300,000,000.0	299,968,882.9	31,117.1	0
Тоног төхөөрөмжийн	210,013,000.0	200,000,000.0	200,377,220.3	-377,220.3	0
Автомашин	110,000,000.0	55,000,000.0	54,985,728.6	14,271.4	0
Аэродром	169,000,000.0	169,000,000.0	168,928,141.8	71,858.2	0
Гал унтраах зардал	15,000,000.0	30,000,000.0	35,366,717.5	-5,366,717.5	-36
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	50,000,000.0	50,000,000.0	43,909,751.8	6,090,248.2	12
Томилолт, зочны зардал	10,000,000.0	-	200,181.5	-200,181.5	-2
Дотоод албан томилолт	10,000,000.0		-	-	0
Гадаад томилолт			200,181.5	-200,181.5	
Гадаад зочны зардал			-	-	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	562,870,100.0	632,161,000.0	614,773,699.6	17,387,300.4	3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,000,000.0	131,412,000.0	131,750,391.0	-338,391.0	
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	18,000,000.0	18,000,000.0	1,339,133.4	16,660,866.6	93
Газрын төлбөр	426,728,400.0	426,728,400.0	424,471,669.2	2,256,730.8	1
Хөрөнгийн даатгал			-	-	
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,000,000.0	10,900,000.0	9,637,125.1	1,262,874.9	21
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	32,141,700.0	45,120,600.0	47,575,380.9	- 2,454,780.9	-8
Бараа үйлчилгээний бусад зардал	-	40,000,000.0	30,927,028.3	9,072,971.7	



Бараа үйлчилгээний бусад зардал	-	40,000,000.0	30,927,027.3	9,072,972.7	
Мэдээлэл сурталчилгааны зардал	23,960,000.0	35,000,000.0	38,586,725.1	-3,586,725.1	-15
Харуул хамгаалалтын зардал	40,000,000.0	60,000,000.0	57,054,953.0	2,945,047.0	7
Холбооны суваг ашигласны хөлс	172,800,000.0	192,456,000.0	192,868,500.0	-412,500.0	0
Үл хөдлөх хөрөнгийн татвар	480,296,500.0	489,484,700.0	525,295,494.4	-35,810,794.4	-7
Биеийн тамирын уралдаан, тэмцээн	-	6,000,000.0	5,951,173.8	48,826.2	
Сургалт семинар	15,000,000.0	15,000,000.0	5,367,928.2	9,632,071.8	64
Дотоод сургалт	15,000,000.0	15,000,000.0	4,989,639.5	10,010,360.5	67
Гадаад сургалт	-		378,288.7	-378,288.7	
Сургалт семинар зохион байгуулах		15,000,000.0	14,503,281.2	496,718.8	
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	893,833,100.0	893,833,100.0	842,331,302.3	51,501,797.7	6
Нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг	216,569,900.0	252,000,000.0	220,668,979.9	31,331,020.1	14
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	647,263,200.0	541,833,100.0	512,703,472.2	29,129,627.8	5
Шагнал урамшуулал, баяр ёслол	30,000,000.0	100,000,000.0	108,958,850.3	-8,958,850.3	-30
Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ	-	7,500,000.0	7,471,980.0	28,020.0	
Валютийн ханшийн зөрүү	-		311,500,737.7	-311,500,737.7	
Шийдвэр гүйцэтгэлийн үнэлгээ		7,479,700.0	7,460,484.0	19,216.0	
Үндсэн хөрөнгийн			669,427,644.1		

7,460,484.0 19,216.0
 ТӨААТҮГ-ийн АУДИТЫН БАЙГУУЛАГА
 01 ЗОРЧИЛГУЙ
 669,427,644.1 САНАЛ ДҮГНЭЛТ

дотоод хөтлөлтийн борлуулалтын гарз				
Орлогын албан татвар			981,594,041.1	
Түрээсийн зардал			515,585,950.1	
<i>Хөрөнгийн элэгдэл</i>		-	3,291,556,566.0	

